МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 06 сарын 23 өдөр Дугаар А/360 Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр журмаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2.1.4, 4.1, Шадар сайдын 2021 оны 129 дүгээр тушаал, Аймгийн засаг даргын зөвлөлийн 2023 оны 05 сарын 31-ний өдрийн 11 дүгээр хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хөвсгөл аймагт сүүлийн жилүүдэд газар хөдлөлтийн давтамж нэмэгдсэнтэй холбогдуулан барилгын чанар, аюулгүй байдал, паспортжуулах ажил зохион байгуулахад 10,0 (арван сая) төгрөгийг зарцуулсугай

2. Дээрх зардлын 10,0 (арван сая) сая төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Б.Мөнгөн-Эрдэнэ)-т зөвшөөрсүгэй.

3. Паспортжуулалтын ажлыг үр дүнтэй зохион байгуулж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Б.Оюунтуяа), Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Б.Ганзориг) нарт үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (М.Хуягбаатар)-д үүрэг болгосугай.

ДАРГА П.ЛХАГВАЖАВ

6710010732